



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 4/27

Биндэр сум

**Сар шинийн баярын өдрүүдэд хариуцлагатай
жижүүр томилон ажиллуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.17-р жарны "Гал морин" жилийн сар шинийн баярын өдрүүдэд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах иргэдийн амгалан тайван байдлыг хангах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүлээр ажиллах хуваарийг хавсралтаар батласугай.

2.Амралт баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Хуваарийн дагуу хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэхдээ байгууллагуудын эргүүл, жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл жижүүрүүдэд үүрэг болгосугай.

4.Дулааны шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга (Г.Баярхүү), эмнэлгийн машиныг байнгын бэлэн байдалд байлгахыг эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Өсөхбаяр) нарт үүрэг болгосугай.

5.Нийтээр амрах баяр, амралтын өдрүүдэд холбогдох дүрэм журам, норм стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангаж, дотоод хяналтын чангатгаж ажиллахыг Шуурхай үйлчилгээ, засварын монтёр (Г.Ононхүү)-д үүрэг болгосугай.

6.Олон нийтийн эргүүлийг хуваарийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Б.Ханхүү)-д үүрэг болгосугай.

7.Хөдөлгөөнт эргүүлд ажиллах эргүүл, жижүүрийн унаа машинд шаардагдах шатахууны зардлыг эрсдэлийн сангаас тооцож гаргахыг Засаг даргыг Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д үүрэг болгосугай.

8.Цагийн байдлын мэдээг 3 (гурван) цаг тутамд аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын жижүүрт мэдээлж, авч хэрэгжүүлсэн ажлын талаарх илтгэх хуудсыг 2026 оны 02 дугаар сарын 24-нд хүргүүлэхийг хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч (Б.Ханхүү)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



Хэвлэсэн
Хэвлэсэн
231800052


Сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар
сарын 13 өдрийн 4/27 захирамжийн
1 дүгээр хавсралт



ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Эргүүлд гарах өдөр	Утас
1	Соёлын төв Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	02 дугаар сарын 17-ны өдрийн 22:00-02:00	98224212 86575657
2	ЕБС Гутай БЦГ	02 дугаар сарын 18-ны өдрийн 22:00-02:00	93151003
3	ЗДТГ	02 дугаар сарын 19-ны өдрийн 22:00-02:00	89027744
4	Ой анги Цэцэрлэг	02 дугаар сарын 20-ны өдрийн 22:00-02:00	88057258 86487474

Сумын Засаг даргын ~~2026~~ оны ~~02~~ дугаар
сарын ~~13~~ өдрийн ~~1/24~~ захирамжийн
2 дугаар хавсралт



ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Эргүүл нь тухайн хуваарьт өдрийн 22:00 цагаас -02:00 цаг хүртэл сумын төвд ажиллана
2. Эргүүлийг, Цагдаагийн тасаг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллуулна.
3. Сумын төвийн байгууллагуудын харуул хамгаалалтыг шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд байгууллагын даргатай ярьж шийдвэрлүүлэх.
4. Эгнээ гудамжинд согтуу буюу хараа хяналтаа алдсан иргэн, хүүхэд байгаа эсэхэд хяналт тавих
5. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.
6. Эргүүлд гарч ажилсан тухай тайлан бичиж өгнө.